



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/66

Арвайхээр сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хайрхандулаан сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын угсралтын ажил дууссан тул “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу дунд төвөгшилтэй барилга, байгууламжийг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (А.Энхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0151

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны... дугаар  
сарын...-ны өдрийн... дугаар  
захирамжийн хавсралт



**ДУНД ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ  
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: А.Энхцэцэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

С.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)

Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Б.Балжинням (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Ахмад)

Н.Сэдэд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын ахлах мэргэжилтэн)

Ч.Ганхуяг (Хайрхандулаан сумын Засаг дарга)

Р.Мягмарсүрэн (Хайрхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн)

Д.Хорлоо (Хайрхандулаан сумын цэцэрлэгийн эрхлэгч)

Б.Загарбат ("Онги-Ус суваг" ОНӨААТҮГ-ын Хайрхандулаан сумын оператор)

Д.Мөнх-Эрдэнэ ("Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Өвөрхангай аймаг дахь салбарын ахлах диспичер)

Д.Мөнхболд ("Монголын цахилгаан холбоо" ТӨХК-ийн Өвөрхангай аймаг дахь салбарын ахлах инженер)

Э.Багахүү (Зураг төслийн "Арвай проект" ХХК-ийн инженер)

Нарийн бичгийн дарга: Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)